

АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2018 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2018 оны 12 дугаар
сарын 03-ны өдөр

Улаанбаатар
хот

Д/д	Үйл ажиллагааны чиглэл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжсэн байдал	Үнэлгээ /хувиар/
Нэг. Авлигын эсрэг үйл ажиллагааны талаар байгууллагаас хүлээх үүрэг				
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах	1.1.1. Онцгой байдлын ерөнхий газраас зохион байгуулах сургалт бүрт Авлигатай тэмцэх газраас холбогдох албан тушаалтнаар Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах яриа таниулга хийлгэх.	1.1.1. Онцгой байдлын байгууллагын 2018 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдсан нийт 34 дотоод сургалтуудад Авлигатай тэмцэх газрын холбогдох албан тушаалтнуудаар авлигын эсрэг үйл ажиллагаатай холбоотой хичээл, сургалтыг хөтөлбөрт нь тусган оруулах арга хэмжээг зохион байгуулсан.	100
		1.1.2. Авлигатай тэмцэх газрын цахим хуудсыг Онцгой байдлын ерөнхий газрын цахим хуудастай холбон мэдээллээр ханган ажиллах.	1.1.2. Авлигатай тэмцэх газрын www.iaac.mn цахим хуудасны холбоосыг онцгой байдлын байгууллагын neta.gov.mn цахим хуудастай холбож, байгууллагын цахим хуудаснаас Авлигатай тэмцэх газрын цахим хуудас руу нэвтрэх, мэдээ, мэдээллийг үзэх боломжтой болсон.	100
2	Хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах	1.2.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын нэгжээс хийх шалгалтын төлөвлөгөөг цахим хуудсанд байршуулах.	1.2.1. Онцгой байдлын ерөнхий газар, харъяа салбар, нэгжүүдэд 2018 онд иж бүрэн болон биелэлтийн хяналт шалгалт зохион байгуулах нэгдсэн хуваарийг Онцгой байдлын ерөнхий газрын даргаар 2018.02.07-ны өдөр батлуулан, байгууллагын neta.gov.mn цахим хуудсанд байршуулсан. Мөн Онцгой байдлын ерөнхий газрын Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын газрын даргын 2018 оны 4/337, 4/338 дугаар албан бичгээр шалгалтад хамрагдах 14 аймгийн Онцгой байдлын газарт хүргүүлсэн. <i>/ОБЕГ-ын даргын 2018.10.29-ний өдрийн А/349 дүгээр тушаалаар ТОНОББ-уудын 2018 оны жилийн эцсийн үйл ажиллагаанд явуулах нэгдсэн шалгалтыг нийт 16 хоногийн хугацаанд зохион байгуулахаар 2018.11.15-ны өдрөөс эхлүүлсэн./</i>	100

		<p>1.2.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын нэгжээс төлөвлөгөөт бус шалгалт хийж, ажлын үр дүн болон шийдвэрийн талаар цахим хуудсаар мэдээлэх.</p>	<p>1.2.2. Баян-Өлгий, Говь-Алтай, Дархан-Уул, Дорноговь, Завхан, Өвөрхангай, Увс, Ховд аймгийн Онцгой байдлын газрын үйл ажиллагаанд хийгдсэн төлөвлөгөөт бус шалгалт болон иж бүрэн ба биелэлтийн шалгалтад хамрагдсан Онцгой байдлын газруудын үйл ажиллагаанд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах хугацаатай үүрэг болон зөвлөмж, шалгалт явуулсан тухай мэдээ, мэдээллийг тухай бүр байгууллагын meta.gov.mn цахим хуудсанд байршуулсан.</p> <p>Мөн дээрх нэгжүүдэд шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний үүрэг, зөвлөмжийг Онцгой байдлын ерөнхий газрын Тэргүүн дэд даргын 2018 оны 2/1275, 2/1490, 2/1513, 2/1514, 2/1515 дугаартай албан бичгээр, шалгалтаар илэрч буй нийтлэг зөрчил, дутагдлыг гаргахгүй байх талаар мэдээлэл зөвлөмжийг 2018 оны 2/1263 дугаартай албан бичгээр төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагуудад хүргүүлэн ажилласан.</p>	100
3	Зөрчил дутагдал, ёс зүйн зөрчлөөс ангид байх	<p>1.3.1. Ёс зүйн зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцлийг тодорхой болгох, байгууллагын хэмжээнд мэдээлэх, дахин тухайн хэлбэрийн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх.</p>	<p>1.3.1. “Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн ёс дүрэм”, байгууллагын дотоод журмыг чанд сахих, ёс зүйн зөрчил гаргахгүй байх баталгааг <i>/Сахилга, ёс зүйн баталгаа/</i> нийт алба хаагчдаар гаргуулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Сахилга хариуцлагыг дээшлүүлэх аян зохион байгуулж, хууль, дүрэм журмаар давхардсан тоогоор 37 удаа 160 цагийн сургалт зохион байгуулсан. Мөн ёс зүйн зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцөл, бололцоог хангах, түүнээс урьдчилан сэргийлэх тодорхой ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Тухайлбал: Авилгатай тэмцэх газрын Олон нийтийн төвд зохион байгуулагдаж буй авилгын эсрэг сургалтад 2018 оны I, II улиралд нийт 163 алба хаагчийг хамруулсан бөгөөд IV улиралд 100 алба хаагчийг хамруулахаар Авилгатай тэмцэх газарт захиалга өгч, хяналт тавьж ажиллаж байна.</p> <p>Ажлын байрны дэг журмыг чанд сахиулж, цэргийн албыг дүрмээр зохион байгуулах, зөрчил дутагдал гаргасан 148 алба хаагчид Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар тухай бүр нь сахилгын арга хэмжээ авч ажилласан байна. <i>/2018.11.01-ний байдлаар/</i></p> <p>Байгууллагын хэмжээнд ёсзүйн зөрчлийн талаарх мэдээллийг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын Ёс зүйн албаар дамжуулан Онцгой байдлын ерөнхий газрын Ёс зүйн хороонд авч, холбогдох шийдвэрийн саналыг тус хорооны хурлаар хэлэлцэж хэвшүүлээд байна.</p>	100

		<p>1.3.2. Зөрчил, дутагдал гаргасан албан тушаалтанд сонсох ажиллагаа явуулах, энэ талаар өөрт нь мэдэгдэж, тайлбар гаргах боломжийг хуульд заасны дагуу олгох.</p>	<p>1.3.2. Захиргааны ерөнхий хуулийн хүрээнд зөрчил, дутагдал гаргасан алба хаагчид сонсох ажиллагаа явуулах, өөрт нь мэдэгдэж, тайлбар гаргуулах арга хэмжээг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018.03.05-ны өдрийн А/86 дугаар тушаалаар батлагдсан “Захиргааны шийдвэрийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэн ажиллаж байна.</p>	100
		<p>1.3.3. Албан тушаалтанд ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг хүргэх, шаардлагатай тохиолдолд нийтэд мэдээлэх.</p>	<p>1.3.3. Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаал, шийдвэрээр сахилгын шийтгэл ногдуулсан алба хаагч бүрт Захиргааны ерөнхий хуулийн 26, 27 дугаар зүйлд заасны дагуу сонсох ажиллагааг явуулан, шийдвэрийг танилцуулж, гарын үзэг зуруулан баталгаажуулах, бүртгэл хөтөлж хэвшүүлэх талаар Онцгой байдлын ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын даргын 2017.09.14-ний өдрийн 3/1875 дугаартай албан бичгээр үүрэг, шийдвэртэй танилцсан бүртгэлийн загварыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагуудад хүргүүлэн, хяналт тавьж ажиллаж байна.</p> <p>Мөн албан тушаалтанд ногдуулан сахилгын шийтгэлийн талаар анги, байгууллага бүр “Мэдээллийн цаг” арга хэмжээний үеэр нийт бүрэлдэхүүнд танилцуулж, зөрчил, дутагдал гаргахгүй байх талаар мэдээлэл өгч байна.</p>	100
4	<p>Ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг гаргах талаар хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт</p>	<p>1.4.1. Сонирхлын зөрчил үүссэн буюу үүсч болзошгүй тохиолдолд мэдэгдэл гаргуулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.</p>	<p>1.4.1. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын ХАСХОМ хариуцсан эрх бүхий 21 албан тушаалтнуудад Авилга ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалт, Захиргааны шийдвэрийн хувийн хэрэг хөтлөх журам, ХАСХОМ бүрдүүлэлтийн системийг ашиглах, холбогдох бусад хууль, тогтоомжийн талаар сургалтыг 2018.04.19-ний өдөр Давтан сургалт, сэргээн заслын төвд зохион байгуулсан.</p>	100
		<p>1.4.2. Алба хаагчдын зүгээс хуулиар зөвшөөрөгдсөн давхар ажил эрхлэх тохиолдолд зөвшөөрөл олгох.</p>	<p>1.4.2. Онцгой байдлын байгууллагын хэмжээнд давхар ажил эрхэлж буй алба хаагчийн мэдээлэл ирүүлээгүй болно.</p>	100

		1.4.3. Алба хаагчдын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг нэгтгэн, хуулийн хугацаанд Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх.	1.4.3. Онцгой байдлын байгууллагаас 2017 оны ХАСХОМ гаргах нийт алба хаагчдын судалгааг гарган нэгтгэж, 2018.01.10-ны өдрийн 1/73 дугаартай албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын 2017 оны ХАСХОМ-ийн нэгдсэн тайланг баталгаажуулан, 2018.02.28-ны өдөр Авлигатай тэмцэх газарт албан бичгээр болон цахим хэлбэрээр хүргүүлсэн. <i>/ОББ-ын хэмжээнд 638 алба хаагч ХАСХОМ мэдүүлсэн./</i>	100
		1.4.4. Алба хаагчдын мэдүүлсэн хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэгт хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах.	1.4.4. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагуудын ХАСХОМ хариуцсан эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан цахим сургалтыг 2018.01.04-ний өдөр Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээлэх төвд, Онцгой байдлын ерөнхий газар, Гамшиг судлалын хүрээлэнгийн нийт бие бүрэлдэхүүнд ХАСХОМ гаргах тухай заавар, сургалтыг 2018.01.05-ны өдрийн мэдээллийн цаг арга хэмжээний үеэр тус тус өгч, Онцгой байдлын ерөнхий газрын вэб сайтад зааврыг байршуулсан. Онцгой байдлын албаны хэмжээнд хамаарал бүхий этгээдийн судалгааг нэгтгэн гаргаж, 2018.05.30-ны өдөр Авлигатай тэмцэх газарт цахимаар хүргүүлсэн.	100
		1.4.5. Шинээр томилогдох, хөрөнгөнд их хэмжээний өөрчлөлт орсон алба хаагчдаас тухай бүр мэдүүлгийг гаргуулан авч бүртгэл хөтлөн цахим санд оруулах, түүнд хяналт тавих.	1.4.5. Онцгой байдлын байгууллагын бүтэц, орон тооны өөрчлөлт болон шинээр, шилжин болон дэвшин томилогдох, хөрөнгөнд их хэмжээний өөрчлөлт орсон нийт 239 алба хаагчдаас ХАСХОМ-ийг шинээр гаргуулан баталгаажуулах ажлыг тухай бүрт нь зохион байгуулж ажилласан.	100
Хоёр. Төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдлыг хангах				
5	Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах	2.5.1. Гамшгаас хамгаалах тухай болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах бодлогын баримт бичиг, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, мэдээлэх.	2.5.1. Гамшгаас хамгаалах тухай хууль болон шинээр батлагдсан хууль, дүрэм, журам, бодлогын баримт бичгийг алба хаагчид болон олон нийтэд сурталчлах хүрээнд байгууллагын neta.gov.mn цахим хуудсанд “Хууль, эрх зүй” гэсэн буланг нээж, 2015-2018 онд батлуулсан дүрэм, журам, зааврыг байршуулсан. Мөн албаны 14 хоног тутмын “Онцгой мэдээ” сонинд “Хуулийн булан” нээж шинээр гарсан хууль, дүрэм, журам, зааврыг цувралаар нийтлэн алба хаагчдад хүргэн ажиллаж байна.	100

		<p>2.5.2. Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлж байгууллагын цахим хуудсанд мэдээллийг тухай бүр байршуулж хэвших.</p>	<p>2.5.2. Онцгой байдлын байгууллагын nema.gov.mn цахим хуудсанд 2018 оны эхний 11 сарын байдлаар нийт 1300 гаруй удаагийн цаг үеийн мэдээ, мэдээлэл нийтлэн олон нийтэд хүргэн ажилласан.</p> <p>Удирдлагаас өгсөн үүрэг чиглэл, шийдвэр, шинээр гарсан тушаал шийдвэрийг ил тод, шуурхай, цаг тухай бүр мэдээлж, нийт 320 мэдээ, мэдээллийг нийтлэсэн.</p> <p>Байгууллагын цахим хуудасны хандалтын тоо сүүлийн 2 жилийн хугацаанд өсч, нийт 1,4 сая гаруй хүн зочилсон байна. Өдөрт тогтмол 900-3500, сард 30-50 мянган хүн хандаж мэдээ, мэдээлэл авч байна. Түүнчлэн байгууллагын nema.gov.mn цахим хуудсыг хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийн нэгдсэн групптэй холбосон явдал нь хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчид Онцгой байдлын албаны үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг шууд, цаг алдалгүй шуурхай авах боломж бүрдсэн. Ингэснээр өдөрт тогтмол 20 гаруй мэдээллийн сайт, сонингоор дамжуулан Онцгой байдлын албатай холбоотой мэдээлэл иргэд, олон нийтэд хүрч байна.</p>	100
		<p>2.5.3. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг ил тод, нээлттэй байлгах, иргэдийн хэрэгцээ хангахуйц мэдээллийг байгууллагын самбарт байрлуулах.</p>	<p>2.5.3. Онцгой байдлын ерөнхий газар, Азийн хөгжлийн банктай хамтран Ядуурлыг бууруулах Япон сангийн санхүүжилтээр “Зуд болон ой, хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхийг бэхжүүлэх нь” төслийн www.crdf.mn вэб сайтыг шинээр хийж, Онцгой байдлын байгууллагын үндсэн сайттай холбосон. Мөн албаны 14 хоног тутмын “Онцгой мэдээ” сонинд төслийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг улирал бүр нийтлэж байна.</p> <p>ЖАЙКА олон улсын байгууллагаас Онцгой байдлын ерөнхий газарт хэрэгжүүлж буй “Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх нь” төслийн багтай хамтран ажиллах, мэдээлэл сурталчилгааны нэгдсэн вэб сайт нээх, ажиллуулах, орон нутгийн гамшгаас хамгаалах боловсрол, гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны нэгдсэн график төлөвлөгөө боловсруулах зэрэг ажлуудыг хэрэгжүүлж байна. Нэгдсэн вэб сайтыг нээх ажлын хүрээнд мэдээлэл солилцох мэйл групп үүсгэж, хэн, хаана, хэзээ, юу буюу 4W мэдээллийг оруулж дуусгасан.</p>	100

6	Хөндлөнгийн хяналтыг бүрдүүлэх	<p>2.6.1. Төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнтэй хамтарч ажиллах.</p>	<p>2.6.1. Авлигын эрсдэлийн үнэлгээ хийхээр “Оюунтан эрдэмтдийн клуб” төрийн бус байгууллагаас 5 ажилтан 2018.04.05-18-ны өдрүүдэд Онцгой байдлын ерөнхий газарт ажилласан бөгөөд тус төрийн бус байгууллагаас явуулж буй санал асуулгыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагад албан бичгээр хүргүүлж, уулзалт зохион байгуулсан.</p> <p><i>/Төрийн байгууллагын шударга байдал, авлигын эрсдэлийг үнэлж, цаашид сайжруулах шаардлагатай асуудлын шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорилготой./</i></p>	100
		<p>2.6.2. Иргэний гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах албан тушаалтны нэр, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах.</p>	<p>2.6.2. Онцгой байдлын ерөнхий газарт мөрдөгдөх “Хөдөлмөрийн дотоод журам”-ын “Өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх” гэсэн зургаадугаар бүлэгт ажилтан, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, түүнийг бүртгэх, хяналт тавих үйл ажиллагааг зохицуулсан заалтуудыг тусган Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018.07.24-ний өдрийн А/244 дүгээр тушаалаар батлуулан мөрдөж байна.</p>	100
		<p>2.6.3. Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааны талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас цахим сүлжээгээр санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авах боломжийг бүрдүүлж, ажиллах.</p>	<p>2.6.3. Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах төвд ирсэн Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг Захиргааны удирдлагын газраас хариуцаж бүртгэлд авч, холбогдох албан тушаалтанд уламжлан, хариуг хуулийн хугацаанд өгч ажиллаж байна.</p> <p>2012-2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд “Иргэд, олон нийттэй харилцах төв”-өөр дамжуулан Онцгой байдлын байгууллагад санал хүсэлт 266, гомдол 60, шүүмжлэл 10, талархал 7, нийт 343 өргөдөл, гомдол ирснээс 3 санал хүсэлт цуцлагдаж, 340 нь бүрэн шийдвэрлэгдсэн.</p> <p>Мөн байгууллагын neta.gov.mn цахим хуудсаар дамжуулан санал хүсэлтийг хүлээн авах холбоосыг ажиллуулан Захиргааны удирдлагын газар, Гамшгаас урьдчилан сэргийлэх газраас хамтран хяналт тавин ажиллаж байна.</p>	100

		<p>2.7.1. Ажлын байрны шаардлагыг бүрэн ханган ажиллаж байгаа алба хаагч, ажилтныг тогтвортой ажиллах, дэвших боломжоор хангаж, төрийн албаны чадахуйн (мэрит) тогтолцоог төлөвшүүлэх.</p>	<p>2.7.1. Онцгой байдлын байгууллагын хэмжээнд 2018 оны 11 дүгээр сарын байдлаар амжилттай ажиллаж буй нийт 125 алба хаагчийг мэрит зарчмаар дэвшүүлэн томилсон. Үүнээс нийт 19 удирдах албан тушаалтны орон тоонд сонгон шалгаруулалтыг Онцгой байдлын байгууллагын хэмжээнд зохион байгуулж, Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн 6 удаагийн хуралдаанаар хэлэлцүүлэн холбогдох журмын дагуу дэвшүүлэн томилсон.</p> <p>Удирдах албан тушаалд нэр дэвшиж сонгон шалгаруулалтад оролцож, сонгогдоогүй 15 алба хаагчийг удирдах албан тушаалтны нөөцөд бүртгээд байна. Мөн байгууллагын бодлогоор жил бүр зарим алба хаагчдыг ОХУ-ын Гал эсэргүүцэх албаны академи, Иргэний хамгаалалтын академи, Хууль сахиулахын их сургуулийн Удирдлагын академид суралцуулан удирдах албан тушаалтны нөөцийг бүрдүүлж, бэлтгэх арга хэмжээг авч байна.</p>	100
7	Хүний нөөцийн чадавхыг сайжруулах	<p>2.7.2. Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам, сул орон тооны зар, сонгон шалгаруулалт явуулах талаарх мэдээлэл, удирдлагын ил тод байдлыг хангах.</p>	<p>2.7.2. Монгол Улсын Шадар сайдын 2016.12.28-ны өдрийн 134 дүгээр тушаалаар батлагдсан “Онцгой байдлын байгууллагын хүний нөөцийн бодлого, заавар”-ыг үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон хэрэгжүүлж байна.</p> <p>Онцгой байдлын ерөнхий газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн санхүүгийн хяналт, дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн, Гамшиг судлалын хүрээлэнгийн гамшигийн статистикч, судлаач сул орон тоог 2018.01.07-ны өдрөөс эхлэн төрийн албаны зөвлөлийн www.csc.gov.mn болон Онцгой байдлын ерөнхий газрын meta.gov.mn цахим хуудсанд тус тус байршуулан иргэдэд нээлттэй ажлын байр зарлаж, нийт 11 иргэн бүртгүүлэн 2018.02.06-08-ны өдрүүдэд шалгалтыг зохион байгуулж, дүнг Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн.</p> <p>Төрөөс баримтлах бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, салбарын хүний нөөцийг хөгжүүлэх зорилгоор “Онцгой байдлын байгууллагын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр” баримт бичгийг төслөөр боловсруулан төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн дунд 2018.04.20-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгуулж, ажлын хэсгийг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018.09.20-ны өдрийн А/293 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна.</p>	70

8	Шилэн дансны тухай хууль, тогтоомжид нийцүүлэн ажиллах	<p>2.8.1. Худалдан авах ажиллагааны 2018 оны төлөвлөгөөг цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээлэх, тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлах, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, 2018 оны худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт зэргийг хуульд заасан хугацаанд цахим хуудсанд байршуулах.</p>	<p>2.8.1. 2018 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Монгол Улсын Шадар сайдаар батлуулж, тендерийн урилгуудыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын tender.gov.mn, Онцгой байдлын байгууллагын neta.gov.mn цахим хуудас, “Зууны мэдээ” өдөр тутмын сонинд тус тус байршуулан нийтэд зарласан.</p> <p>Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээллийг тухай бүр tender.gov.mn, shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулан мэдээллэж байсан болно.</p> <p>2018.11.12-ны өдрийн байдлаар улсын төсвийн хөрөнгө оруулалт, төсвийн урсгал зардал, зээл, хандив тусламж зэрэг эх үүсвэртэй 34 цахим тендерийг зохион байгуулсан.</p> <p><i>/ОББ-ын 2018 оны худалдан авах ажиллагаанд аудит хийгдэж байгаа бөгөөд дууссаны дараа тайлан, дүгнэлтийг байгууллагын цахим хуудсанд байршуулахаар ажиллаж байна./</i></p>	70
		<p>2.8.2. Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байх.</p>	<p>2.8.2. Онцгой байдлын ерөнхий газраас 2018 онд зохион байгуулсан нийт нээлттэй болон харьцуулалтын тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд Монголын хуульчдын холбоо, Монголын барилгачдын холбоо, Гал унтраах техникийн олон төрөлт спортын холбоод зэрэг төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөллийг оролцуулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу зохион байгуулсан.</p>	100
		<p>2.8.3. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалт гаргаж цахим хуудсанд байршуулах.</p>	<p>2.8.3. Онцгой байдлын албанаас 2016, 2017, 2018 онд цэргийн тэтгэвэрт гарч тэтгэвэр тогтоолгосон болон нэг удаагийн тэтгэмж авах алба хаагчдын жагсаалт /194 алба хаагч/-ыг Онцгой байдлын ерөнхий газрын даргаар 2018.05.21-ний өдөр батлуулан, байгууллагын www.neta.gov.mn сайтад байршуулсан бөгөөд тэтгэмжийг жагсаалтын дагуу олгож байна.</p>	100

		<p>2.8.4. 2018 оны төсөв, 2017 оны төсвийн гүйцэтгэл, 2019 оны төсвийн төсөл, 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, 2018 оны төсөвт орсон өөрчлөлт /ороогүй бол мэдээллэх/, төсвийн орлого бүрдүүлэлтийн мэдээлэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт зэргийг хуульд заасан хугацаанд цахим хуудсанд байршуулах.</p>	<p>2.8.4. 2018 оны төсөв, 2017 оны төсвийн гүйцэтгэл, 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн орлого бүрдүүлэлтийн мэдээлэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт зэргийг хуульд заасан хугацаанд цахим хуудсанд байршуулсан. 2018 оны нэгдсэн төсөвт тодотгол хийгдээгүй боловч батлагдсан төсвийн хүрээнд орон нутгийн анги, байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой үүссэн өрийг цаг тухай бүр нь Сангийн яаманд хандан төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан шийдвэрлэж, өөрчлөлтийг хугацаанд нь цахим хуудсанд байршуулж мэдээлсэн болно.</p> <p>Онцгой байдлын ерөнхий газрын харъяа зарим салбар, нэгжийг нэгтгэн, бүтцийг шинэчлэн баталж, улмаар төсвийг нэгтгэсэнтэй холбогдон шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллэх багууллагуудаас Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 66 дугаар, 2018 оны 114 дүгээр тогтоолын дагуу төсвийг нэгтгэн 22 салбар, нэгж нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1.1.1 дэх заалтаас хасагдсан тул Сангийн яамны Төрийн захиргааны удирдлагын газарт 2018.10.09-ний өдрийн 4/2270 дугаартай албан бичгээр хүргүүлж, хасалт хийлгэж шийдвэрлүүлсэн.</p> <p>Мөн 2019 оны төсөв батлагдсантай холбогдуулж хуулийн хугацаанд нь цахим хуудсанд байршуулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.</p>	90
		<p>2.8.5. Олон улсын болон дотоодын хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах, хуваарилах ажлыг олон нийтэд ил тод байлгаж хэвлэл мэдээлэл, цахим хуудсаар мэдээлэх.</p>	<p>2.8.5. Олон улсын болон дотоодын хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах, хуваарилах ажлыг олон нийтэд ил тод байлгах зорилгоор байгууллагын цахим хуудас болон албаны сонинд 120 гаруй мэдээллийг нийтэлж хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилан ажилласан.</p> <p>“Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам”-ыг Засгийн газрын 2018 оны 271 дүгээр тогтоолоор батлуулан байгууллагын сонин, цахим хуудсанд байршуулан олон нийтэд хүргэсэн.</p> <p>Онцгой байдлын байгууллагад олон улсын болон дотоодын хүмүүнлэгийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс ирүүлсэн хандив тусламжийн мэдээлэл, нэрийн жагсаалт зэрэг 600 гаруй мэдээ, мэдээллийг тухай бүр байгууллагын цахим хуудсанд байршуулахаас гадна хэвлэл мэдээллийн хэрэгсэл, “Өдрийн сонин”, “Өнөөдөр”, “Зууны мэдээ” зэрэг сонин, сайтад байршуулан олон нийтэд мэдээллэх ажлыг зохион байгуулсан. Түүнчлэн аж ахуйн нэгж</p>	100

			байгууллага, иргэдээс ирүүлсэн хандивын нэгдсэн мэдээллийн талаар хэвлэлийн бага хурлыг 3 удаа зохион байгуулж, холбогдох албан тушаалтнуудыг олон нийтийн телевизийн болон өдөр тутмын сонины ярилцлагад оруулж ил тод байдлыг хангаж ажилласан.	
Нийт төлөвлөсөн арга хэмжээ	25 арга хэмжээ		Төлөвлөгөөний хэрэгжилт /хувиар/	97,2 %

---o0o---